

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН \ 2025.4 сар \

НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохицтойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, ур дунтэй бүтэц байна

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	<i>1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг, үүргийг нарийвчлан зохицуулж, мөрдөж байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг батлан мөрдөж байна. \ТУЗ-ийн 2012 оны 02 тоот тогтоолоор баталсан\	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг өмнө нь хүргүүлсэн.	2	100%
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан иэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i>	ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах асуудлаар Нэр дэвшүүлэх хорооноос чиглэл, зөвлөмж гаргаж компанийн цахим хуудсаар нийтэд зарлаж, дүнг ТУЗ-д танилцуулан ажиллаж хэвшийн. ХЭХ-аар ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцэхийн өмнө тухайн үед ажиллаж байгаа ТУЗ-ийн гишүүдээс санал авч өгсөн саналын үндсэн дээр улируулан ажиллауулах шийдвэр гаргадаг.. Залгамж халааны бодлогын баримт бичгийг ТУЗ-ийн 2023 оны 3 сарын 15-ны өдрийн хурлаар баталсан.	Тогтоолыг хүргүүлсэн.	2	100%
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшилийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандaa байришуулна.</i>	Энэ асуудлыг жилийн үйл ажиллагааны тайланд тусгахаас гадна, хувьцаа эзэмшигчдэд дэлгэрэнгүй мэдээллийг өгч ажилладаг.	Үйл ажиллагааны тайланг СЗХ, Хөрөнгийн биржид тогтмол хүргүүлж байгаа. ТУЗ-ийн гишүүдтэй холбоотой танилцуулга, мэдээллийг СЗХ-нд ирүүлсэн маягтын дагуу хүргүүлж ажилласан.	2	100%
4	<i>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай</i>	ТУЗ-ийн дэргэд Аудитын, Цалин урамшууллын, Нэр дэвшүүлэх хороо ажилладаг. Эдгээр хорооны ажиллах журмыг 2018 оны 07 тоот тогтоолоор баталсан. Хороодын бүрэлдэхүүнд орсон	Хороод байгуулсан тогтоол, түүний бүрэлдэхүүнд орсон	2	100%

	<i>турилагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i>	Хамгийн сүүлд 2025 оны 03 сарын 13-ны өдөр 04 тоот тогтоол гаргаж хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, хороодын даргаар Хараат бус гишүүдийг томилсон болно.	шийдвэрийг МХБ болон СЗХ-нд хүргүүлж ажилласан.		
5	<i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогодоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил уургээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох тэлгээри шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	ТУЗ-ийн гишүүд бүгд компанийн засаглалын сургалтад хамрагдсан, гэрчилгээтэй. Нээлттэй нийгмийн форум, МХБ, Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулдаг сургалт, семинарт ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хамрагддаг. Эрх бүхий байгууллагаас гаргасан журам, дүрэм, зааврыг ТУЗ-ийн гишүүдэд байнга мэдээлж ажилладаг.	ТУЗ-ийн бүрэлдэхүүнд зориулсан сургалтын төвлөвлөгөө гаргадаггүй. Шаардлагатай асуудлаар мэдээ мэдээлэл өгөх, харилцан санал солилцох хэлбэрээр ажилладаг_ Шинээр томилогдсон Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ нь Компанийн засаглалын сургалтад хамрагдан, гэрчилгээ авсан болно.	2	100%
6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах чиглэлээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хууль, дүрэм, ТУЗ-ийн хурлаар баталсан журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. ТУЗ-ийн даргатай байнга харьцаж, ТУЗ-өөс өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж ажилладаг.	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын хэрэгжүүлэх чиг үүрэг нь Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд нарийн тусгагдсан.	2	100%
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	<i>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	ТУЗ-ийн гишүүн 9 хүн байдаг бөгөөд үүнээс 3 нь хараат бус гишүүн байна.	Хараат бус гишүүд бүх хороодыг удирддаг.	2	100%
8	<i>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүснэгтээр оролцно.</i>	Аудитын хороо нь ажиллах журамтай. \ ТУЗ-ийн 2018 оны 7-р тогтоолын 3-р хавсралтаар баталсан\ Аудитын хорооны дарга Д. Энхтогтох нь Хараат бус гишүүн. ТУЗ-ийн дарга бус. Аудитын хороо нь орон нутагт тогтмол ажилладаг бөгөөд компанийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх шаардлагатай асуудлаар байнга зөвлөмж өгч, хэрэгжилтийг тооцож ажилладаг. Шаардлагатай үед компанийн гүйцэтгэх	Аудитын хорооны ажиллах журмыг хүргүүлж ажилласан.	2	100%

		удирдлага, санхүүгийн ажилтнууд Аудитын хорооны хуралд оролцдог.			
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагчхүү хорооны хүсэлтээр оролцно.	Цалин урамшууллын хорооны ажиллах журмыг ТУЗ-ийн 2018 оны 7-р тогтоолын 5-р хавсралтаар баталсан. Цалин урамшууллын хорооны дарга ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажилладаггүй ТУЗ-ийн даргаар ажиллаж байсан. \ 2025 оны 3 сараас Хорооны даргаар Хараат бус гишүүн Т.Мөнхгэрэл ажиллах болсон\ 2024 онд Компанийн ажилтан, ажилчдын цалинг 20 хувиар нэмэгдүүлсэн. Энэ асуудлыг Цалин, урамшууллын хорооны хурлаар танилцан улмаар ТУЗ-ийн 2024.04.30-ны өдрийн 13 тоот тогтоолоор” Цалингийн санд өөрчлөлт оруулж, төсөвт тодотгол хийх тухай” тогтоол гаргасан байна. Намрын тариа хураалтын үеэр Утрэмийн ажилчдын цалинг 20-25 хувиар 2 удаа шатлалттайгаар нэмэгдүүлсэн.	2	100%	
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Нэр дэвшүүлэх хорооны ажиллах журмыг 2018 оны 07 тоот тогтоолын 4-р хавсралтаар баталсан. Нэр дэвшүүлэх хорооны даргаар Хараат бус гишүүн Л.Давааг 2025 оны 3 сараас томилсон. Залгамж халааны бодлогын баримт бичигтэй.	.	2	100%
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон тур хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	ТУЗ-ийн дэргэд байнгын хороо ажилладаггүй. Шаардлагатай асуудлаар Ажлын хэсэг байгуулж ажилладаг. ТУЗ-ийн бүх хороод Ажиллах журамтай.	Компанийг өөрчлөн байгуулах асуудлаар Ажлын хэсэг байгуулж байсан.	2	100%
12	ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана 3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журамыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Компанийн мэдээллийн үйл ажиллагааны журмыг 2017 оны 12 сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор батлан мөрдөж ажиллаж байна. Мөн СЗХ-ноос баталсан журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилладаг. МХБ-ээс баталсан	.	2	100%

		“Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”ыг хэрэгжүүлж ажиллаж байна.			
13	3.2. ТУЗ нь энхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Хөвсгөл алтан дуулга ХК-ийн Ногдол ашиг хуваарилах журам, Хувьцаа эргүүлэн худалдан авах үйл ажиллагааны журам, Мэдээллийн үйл ажиллагааны журам, Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх сонирхлын зөрчлийг зохицуулах журам \ 2017 оны То- 17-08 тоот тогтоол\, Энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээний тухай тогтоол \ 2018 оны То-18-17 тоот тогтоол\ , Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам, Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам \ 2020 оны 02 тоот тогтоол \ гэх мэт Компанийн засаглалтай холбоотой өөрийн баталсан журам, дүрмийг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэж ажиллаж байна.		2	100%
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлгнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайллан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлоөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хурсэн эсэхийг үзлэсэн мэдээлэл байна.	Санхүүгийн бус зорилгын хүрээнд тогтвортой хөгжлийн зарчмыг ажлын, амьдралын, хүрээлэн буй орчинд бий болгохын төлөө мэдлэг, түүх туршлага хуримтлуулан байгууллагын хөгжлийн зорилгодоо тусган, баяжуулан ажиллахыг эрмэлзэж байна.		2	100%
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нохцол боломжсоор хангах талаар тусгажс, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Аудитын хорооны журамд энэ асуудал тусгагдсан. Хөндлөнгийн аудитыг сонгох, түүнтэй гэрээ байгуулах асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн Гүйцэтгэх захиралд үүрэг өгч ажилладаг. Хөндлөнгийн аудитын байгууллага нь компани дээр байрлан ажилладаг, чиг үүргээ хэрэгжүүлэх боломжоор байнга хангаж ажиллаж байна.		2	100%
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн эзлжит хуралд оролцожс, аудиттай холбоотой	Өмнөх жилүүдэд Хөндлөнгийн аудитороор ажиллаж байсан “Од бүртгэл аудит” \ МҮҮР аудит болсон\ -ын төлөөлөл ХЭХ-д тогтмол оролцож байсан.	2023,2024 оны ХЭХ-д Хөндлөнгийн аудитор оролцоогүй. Цаашид	1	50%

	асуудлаар хувьцаа эзэмшигчдээд мэдээлэл өгдөг байна.		хуралд оролцож байх талаар мэдэгддэг.		
17	<i>4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг уүрэг, тэдгээрт орсон оорчлолтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.</i>	Дотоод аудитын тогтолцоо, горим, ажилбар уялдаа холбоог дахин эргэн харж, мэдээллийн нээлттэй байдлыг илүү хангасан дижитал мэдээллийн сагсыг олон нийтэд хүргэх ажлыг тогтмолжуулна. Санхүүгийн чиглэлийн асуудал хариуцсан дотоод аудитаар Аудитын хорооны дарга Д.Энхтогтох ажиллаж байгаа. Чанар, эрүүл ахуйн асуудлаар дотоод аудитыг бэлтгэсэн. Ажиллаж байгаа..		1	50%

ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина

18	<i>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Үйлдвэрлэлийн цикл болон улирлын чанартай ажлын орчинд эрсдэлийн удирдлага, аюулгүй ажиллагааны горим дүрэм, баримтлан, асуулга судалгаа жилд 1-2 удаа явуулдаг.		1	50%
19	<i>5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошигүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлagnана.</i>	ТУЗ-ийн дэргэд ЭУ хариуцсан хороог үйлдвэрлэлийн бүхий л ёш шат, санхүү тайлагнал зэрэг орчинг хамарсан хүртээмжтэй байдлаар шинэчилэн зохион байгуулан ажиллаж байна.	Үр дүнг ёш шаттай харааар төлөвлөн ажиллаж байна.	1	50%
20	<i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эруул мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд</i>	Байгаль орчин, үйлдвэрлэлийн дотоод орчин, ажиллагдын орчин нөхцлийн үнэлгээ, дүгнэлтийг компанийн дотоод нөөцдөө тулгуурлан тодорхойлох, ногоон болон тогтвортой хөгжлийг дэмжигч, санхүүжүүлэгч байгууллагуудыг судлан санал төслөө явуулах асуудлууд Компанийн бизнес	Байгаль орчин, нийгэм засаглалын судалгааг гаргаж ажилласан.	2	100%

	<p>мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдааж буйгаа тайлбарлана.</p>	<p>төлөвлөгөө болон ТУЗ-ийн ажлын чиглэлд тусгагдсан болно. Чанар, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангах тодорхой зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Компанийн дэргэд ажилладаг дотоод хяналтын лабораторийг магадлан итгэмжлэгдсэн лаборатори болгон өргөжүүлж, лабораторийн чанарын гарын авлага боловсруулан, түүнийг дагасан 24 журмыг батлуулсан. Хими болон ургамал хорио цээрийн 2 дэд лабораторид нийт 6 бүтээгдэхүүнд 19-22 үзүүлэлтийн дагуу шинжилгээ хийж байна. Лабораторийн ўйл ажиллагаа нь чанарын тогтолцооны шаардлагад нийцэж буйг тодорхойлох зорилгоор дотоод аудитыг дэд лаборатори тус бүрт 2 удаа хийсэн. Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр эрх бүхий байгууллагын төлөвлөгөөт бус хяналт шалгалтад амжилттай хамрагдсан. “Дэмч ир гүн” ХХК-иар компанийн ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулсан.”Ургахам” ХХК-иар нийт 4500м2 талбай, 6600 тонны агуулахад, өөрсдийн хүчээр 2400м- талбайд ариутгал, халдвартгүйжүүлэлт хийсэн. Ажилчдын хувцас, хамгаалах хэрэгслийн журам, Архи, согтууруулах ундаа, мансууруулах бодистой тэмцэх журмыг Гүйцэтгэх захирлын тушаалаар батлан мөрдөж байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээний сургалтыг 2 удаа зохион байгуулсан.</p>		
21	<p>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</p>	<p>Компанийн онцлогт тохирсон KPI хэрэгжүүлэх арга аргачлалыг тодорхойлж, хэрэгжүүлэх, энэ үнэлгээнд сууриссан цалин урамшууллын зөв системийг бий болгох зорилт дэвшүүлэн ажиллаж байгаа. Тусгайлсан бүтэц байхгүй. Компанийн засаглалын асуудлаар ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга нар албан ажилтнуудад байнга мурглалт, мэдээлэл өгч ажилладаг.</p>	1	50%
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ				
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна				
22	<p>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр,</p>	<p>ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг ХЭХ-аар ил тод хэлэлцэж баталдаг.</p>	2	100%

	дэвтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.			
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	ГЗ-тай байгуулах контрактыг гэрээг шинэчлэх, ажил дүгнэх үзүүлэлт, аргачлалыг тодорхой болгох, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн үндсэн цалин, шагнал, бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг Дотоод журмаараа тогтоосон.		2 100%
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн, ТУЗ-өөс дүгнэлт гаргаж ХЭХ-аар хэлэлцүүлж батлуулдаг. Компанийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгдөг. Энэ дүгнэлтийн үндсэн дээр урамшуулал олгох эсэх асуудлыг шийдвэрлэж байгаа.	ХЭХ-ын 2022 оны тогтоолыг хавсаргав.	2 100%
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ				
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлийн				
25	7.1. Компани нь ТУЗ-оос баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Талуудын харилцаа, эрх тэгш байж, нээлттэй байх тал дээр хамтран харилцан хүндэтгэлтэй байж, ажил хэрэгч соёлыг нутагшуулж ажиллаж байна. ТУЗ-өөс оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичгийг батлаагүй. Шаардлагатай тохиолдолд гэрээ байгуулан ажиллаж байгаа. Оролцогч талуудтай гэрээ байгуулан ажиллахдаа төлбөр болон хугацааны хувьд илүү уян хатан байж, харилцагчийн санал бодлыг чухалчилдаг. Гэрээний зүйл заалтыг бүрэн хэрэгжүүлэх чиглэлээр иднвхтэй ажиллан, харилцагч талуудын итгэлийг олж авч, тууштай хамтран ажиллахыг гол зарчмаа болгодог.		2 100%
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Жилийн тайлан, ХЭ-ийн хурлын бэлтгэл, оролцоог хангах тал дээр Ажлын хэсэг ажиллаж, санал бодол, хүсэлтийг дэмжиж, хамтран илүү үр дүнтэй байхыг зорьсон саналыг дэмждэг.		2 100%

27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажилтуулна.	Санал хүсэлтийн мөрөөр, мөн явцын дунд харилцан мэдээлэл туршлага, мэдлэг солилцох ажлууд үе шаттай хийгдэж, үр дүнгээ алхам алхамаар гаргаж байгаа болно.		2	100%
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдолыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дэшилүүлэх дотоод журам, ажлын толovelгөөтэй байна.	Компанийн дотоод журмыг 2024 онд шинэчлэн баталсан. Компанийн Гүйцэтгэх удирдлагын зүгээс Нийгмийн даатгалын шимтгэл, түүнээс олгох тэтгэмж, Чихрийн шижин өвчинөөс урьдчилан сэргийлэх зэрэг асуудлаар сургалт зохион байгуулж гадны байгууллагаас албан тушаалтан урьж хийлгэсэн. Мөн Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал, Ажлын байран дахь ёс зүй зэрэг асуудлаар 5 удаагийн дотоод сургалт зохион байгуулсан байна. 2024 оны 7-8 сард УБ хот дахь Рехамед эмнэлэгтэй хамтран 40 ажилтныг нэгдсэн журмаар эрүүл мэндийн иж бүрэн үзлэгт хамруулсан байна. Нэг хүний үзлэгийн зардал болох 650000 төгрөгийг Компани өөрөө бүрэн хариуцсан. Компанийн нэрэмжит гар бөмбөгийн тэмцээнийг аймгийн хэмжээнд зохион байгуулж 30 гаруй багийн 200 орчим тамирчид оролцож, энэ арга хэмжээнд компанийн ажилчид идэвхтэй оролцсон. “Ажилчдын нэг өдөр” 6 төрөлт тэмцээнийг уламжлал болгон жил бүр зохион байгуулж байна.		2	100%

НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ

ТҮЗ-ийн гишүүд компанийд бизнесийн ёс зүйн өндөр хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно

29	8.1. Компанийн үзүүт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлжс, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТҮЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	ТҮЗ-өөс Ёс зүйн дүрмийг баталсан. Компанийн ажилтан, албан хаагчдын дунд Ёс зүйтэй холбоотой асуудлаар сургалт зохион байгуулсан.	Ёс зүйн дүрмийг МХБ-д хүргүүлж, цахим хуудастаа байрлуулсан.	2	100%
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зорчлийг ТҮЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үзээгчийн” тогтолцоотой байна.	Компанийн дотоод журам, ёс зүйн дүрмээр зохицуулдаг.		2	100%

31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хөргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Компанийн дотоод журам, ёс зүйн дүрмээр зохицуулдаг.		2	100
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Шинэ мэдээллийг тухай бүр хүргэж байгаа, гэхдээ давтамж агуулгыг баяжуулна. Уулзалт, ярилцлага хэлбэрээр энэ асуудлыг зохион байгуулдаг.		2	100%
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хотолбортой байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцож цахим сувгийг хөгжүүлнэ.	Дижитал суваг, бусад нээлттэй сувгаар харилцааг хөгжүүлж сайжруулалтыг хийнэ. Хөрөнгө оруулагчидтай Харилцах тусгайлсан хөтөлбөр байхгүй.	Шаардлагатай тохиолдолд Гэрээ, контракт байгуулж ажилладаг тул тусгайлсан хөтөлбөр шаардлагагүй гэж үзж байна.	2	100%
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах эзрг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нохцолийг бүрдүүлийн.	Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмыг батлан мөрдөж байгаа. Мөн Монголын хөрөнгийн бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Үнэт цаас арилжаалагчдын холбоо, Төв орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд цаг тухай бүр нь хүргүүлж ажилладаг.		2	100%
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, омчлолийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхд нь онцгойлон анхаарна.	Компанийн үйл ажиллагаа, зорилт, төлөвлөгөөний талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгч ажилладаг. Санал, хүсэлтийг сонсдог. Хувьцаа эзэмшигчид, хэрэглэгчдийг хүлээн авах өдөртэй болох, санал хүсэлтийн дэвьэр ажиллуулах г.м хэлбэрээр ажиллана.		2	100%
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зорчигдохөөс сэргийлэх зорилгоор	Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх сонирхлын зөрчлийг зохицуулах журамтай. \ 2017 оны То- 17-08 тоот тогтоол\		2	100%

сонирхлын зөрчилтэй хэлил хийх журамтай байх ба хэрэгжүүлийг нийтэд мэдээлнэ.				
НЭГДСЭН ДҮН				